



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР

Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах үйл явц хууль тогтоомж зөрчсөн байна

Аудитын сэдэв: Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө

Аудитын код: ГНАГ-2025/11-ШТА-НА

Аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Б.Сандуйжав

Утас: 261639, Цахим хаяг: sanduijavb@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор Ж.Чинбат

Цахим хаяг: chinbatj@audit.gov.mn

Аудитор А.Мөнхбадрал

Цахим хаяг: munkhbadrala@audit.gov.mn

Аудитор С.Оюун-Эрдэнэ

Цахим хаяг: oyun-erdenes@audit.gov.mn

Аудитор С.Номин-Эрдэнэ

Цахим хаяг: nomin-erdenes@audit.gov.mn

Аудитор А.Төгөлдөр

Цахим хаяг: tuguldura@audit.gov.mn

Аудитор Б.Ариунзаяа

Цахим хаяг: ariunzayab@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт	4
Дүрслэлийн жагсаалт	4
Хавсралтын жагсаалт	4
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	5
Аудитын зорилго	5
Аудитын хамарсан хүрээ	5
Аудитын арга зүй	5
Аудитын шалгуур үзүүлэлт	5
Аудитын багийн бүрэлдэхүүн	6
БҮЛЭГ 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хууль тогтоомжийн дагуу хугацаандаа бодитой батлагдахгүйгээс тусгай дансны орлого бүрэн төвлөрөхгүй байна. 8	
Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгө байршуулах хууль тогтоомжийн зохицуулалтууд ялгаатай байна	8
Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны орлогыг жил бүр бүрэн төвлөрүүлээгүй байна	15
БҮЛЭГ 2. Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна	20
Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг буцаан олгох хууль тогтоомжийн зохицуулалт ялгаатай байна	20
Нөхөн сэргээлтийн үйл явц хангалтгүй, эвдэрсэн талбайг бусад эх үүсвэрээр санхүүжүүлж нөхөн сэргээж байна	26
ДҮГНЭЛТ	34
ЗӨВЛӨМЖ	35
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	36
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР.....	37

Товчилсон үгийн тайлбар

ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах ажил
НА	Нийцлийн аудит
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОНБУТХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
БОМТБХБТЖ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
БОХНСБТДГХТЖ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СаЯ	Сангийн яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
БОСШТ	Байгаль орчны судалгаа шинжилгээний төв
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ААН	Аж ахуйн нэгж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан ч БОМТ батлагдаагүй тусгай зөвшөөрлийн тоо, мөнгөн дүн	12
Хүснэгт 2	БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч	13
Хүснэгт 3	БОМТ, биелэлтийн тайлангийн мөнгөн дүн	14
Хүснэгт 4	Баталгааны тусгай дансанд байршуулбал зохих болон байршуулсан мөнгөн хөрөнгийн дүн	15
Хүснэгт 5	Баталгааны мөнгөн хөрөнгө байршуулаагүй БОМТ батлуулсан тусгай зөвшөөрлийн тоо, мөнгөн дүн	16
Хүснэгт 6	Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны тоо	18
Хүснэгт 7	Бичил уурхай эрхлэгчдийн 2020-2025 онд барьцаа хөрөнгө байршуулсан мэдээлэл	19
Хүснэгт 8	Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны зарлага	22
Хүснэгт 9	Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны зарлага	23
Хүснэгт 10	Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны зориулалт бус зарцуулалт	24
Хүснэгт 11	Нөхөн сэргээлтийн дундын дансны 2020-2025 оны зарлага	25
Хүснэгт 12	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл	26
Хүснэгт 13	Төлөвлөсөн нөхөн сэргээлт хийгээгүй БОМТ-ний биелэлтийн тайлан батлагдсан тусгай зөвшөөрлийн тоо	26

Хүснэгт 14	Нөхөн сэргээлт төлөвлөөгүй БОМТ батлуулж, биелэлтийн тайлан батлагдсан тусгай зөвшөөрлийн тоо	27
Хүснэгт 15	Эвдэрсэн газрын мэдээлэл	29
Хүснэгт 16	Эвдэрсэн талбай, түүний нөхөн сэргээлт	29
Хүснэгт 17	Нөхөн сэргээлтийн зардлын эх үүсвэр	30
Хүснэгт 18	Эвдэрч эзэнгүй орхигдсон талбай, түүний нөхөн сэргээлт	30
Хүснэгт 19	Нөхөн сэргээлтийн зардлын эх үүсвэр	30
Хүснэгт 20	Хууль бус ашигт малтмал олборлосон зөрчлийн шийдвэрлэлт	31
Хүснэгт 21	Зөрчлийн шийдвэрлэлт	32
Хүснэгт 22	Зөрчлийг шийдвэрлэсэн байдал	32
Хүснэгт 23	БОМТ-ний биелэлтийн тайлан	33

Зургийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Зураг 1	Тусгай зөвшөөрлийн байршил	7
Зураг 2	Эвдэрч орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийхийн өмнөх болон дараах байдал	23

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах үйл явцын зураглал	12
Дүрслэл 2	БОМТ-г илгээсэн, хянасан, баталсан цаглавар	13
Дүрслэл 3	БОМТ батлуулсан байдал	15

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрлийн жагсаалт
Хавсралт 2	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч нөхөн сэргээгдээгүй газар

Аудитын зорилго, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн аудитыг хийлээ.

Аудитын зорилго

Уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны талаарх үйлчилж байгаа хууль тогтоомж, үйл ажиллагааны тогтолцоо нь үр нөлөөтэй эсэх, тусгай дансанд орлогыг бүрэн төвлөрүүлж уг хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхийг тодорхойлоход аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд орлого бүрдүүлэх үйл явц хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжсэн эсэх;
- Уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад уул уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд оролцож буй талууд болох Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Сангийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Аймаг, нийслэлийн байгаль орчны газар, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөл хэрэгжүүлэгч болон мэргэжлийн байгууллагууд, хуульд заасан бусад байгууллагуудыг хамруулж уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны 2020-2025 оны орлого, зарлага, тайлан, мэдээ, судалгаа, шинжилгээ, гаргасан шийдвэрүүд болон бусад баримт материалын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Үндсэн хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Эрүүгийн хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;

- Төсвийн тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Газрын тосны тухай хууль;
- Цөмийн энергийн тухай хууль;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль;
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Газрын хэвлийн тухай хууль;
- Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал /2015 он/;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам /2019 он/;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам /2014 он/;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам /2025 он/;
- Уурхай, Уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам /2019 он/;
- Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх, хүлээн авах заавар /2022 он/;
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журам;
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, техникийн ерөнхий шаардлага MNS6200:2010;
- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5914:2008;
- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008;
- Холбогдох бусад хууль тогтоомж;
- Олон улсын болон дотоодын байгууллага, судлаачдын нөхөн сэргээлтийн асуудлаар хийсэн судалгаа, тайлан, дүгнэлт.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Б.Сандуйжав үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ш.Наранбаатар, Ж.Чинбат, А.Мөнхбадрал, С.Оюун-Эрдэнэ, С.Номин-Эрдэнэ, А.Төгөлдөр, Б.Ариунзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын хүндрэл бэрхшээл

Аудитад 2020-2025 оныг хамруулсан боловч БОУАӨЯ-ны байгаль орчны мэдээллийн санд 2020-2022 оны БОМТ байршаагүй, шаардлагатай баримт материалыг гаргаж өгөхдөө хугацаа хоцроосон, аймгуудаас гарах мэдээлэл бүрэн бус бөгөөд нэгтгэл нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад байдаггүй зэргээс шалтгаалж аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхэд хүндрэл учруулж, зарим судалгаа, тоо мэдээнд хязгаарлалт хийхэд хүргэсэн болно.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын хэмжээнд 2020-2025 онд 2581 ААН нийт 4259 ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа нь нийт газар нутгийн 4.3 хувийг эзэлж байна. Тусгай зөвшөөрлийг газарзүйн байршлаар харуулбал дараах байдалтай байна.

Зураг 1: Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн байршил, 2025 он



Эх сурвалж: АМГТГ-ын цахим мэдээллийн сан

Тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа 2581 ААН-ээс 1279 нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт үйл ажиллагааны чиглэл нь “Уул уурхайн ашиглалт, олборлолт хайгуул”-аар бүртгүүлсэн байна. Энэ нь ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны чиглэл нь зөвхөн уул уурхайгаар хязгаарлагдахгүй байгааг харуулж байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуульд зааснаар БОУАӨЯ-ны байгаль орчны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд ашигт малтмалын ашиглалт, баяжуулах үйлдвэр, газрын тосны ашиглалт, газрын тосны хайгуулын, цацраг идэвхт ашигт малтмалын барьцаа хөрөнгийг төвлөрүүлдэг бол сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд ашигт малтмалын хайгуул, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, хайгуул, химийн үйлдвэрийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлдэг байна. Бичил уурхай эрхлэгч этгээдийн барьцаа хөрөнгийг тухайн сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд төвлөрүүлдэг байна.

Уул уурхайн үйл ажиллагааны нөхөн сэргээлтийн сан гэсэн нэршилтэй данс байхгүй бөгөөд байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа мөнгөн хөрөнгийг төрийн сангийн “Байгаль орчны нөхөн сэргээх баталгаа” нэртэй тусгай дансанд төвлөрүүлдэг байна.

Нарийвчилсан харилцааг зохицуулах "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам"-г Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/04 дүгээр тушаалаар баталж, БОУАӨС-ын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны А/38 тоот тушаалаар шинэчлэн баталжээ.

БҮЛЭГ 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хууль тогтоомжийн дагуу хугацаандаа бодитой батлагдахгүйгээс тусгай дансны орлого бүрэн төвлөрөхгүй байна.

Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгө байршуулах хууль тогтоомжийн зохицуулалтууд ялгаатай байна

1.1. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд орлого бүрдүүлэх үйл явцыг хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Хууль тогтоомж	Зүйл, заалт	Бусад хууль тогтоомжид утга агуулгын хувьд ялгаатай туссан байдал
Ашигт малтмалын тухай хууль	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч: Хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8-д “байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх”	БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалттай нийцээгүй. Уг заалтад төсөл хэрэгжүүлэгч нь сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулахаар заасан.
	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч: Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.9-д “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу зохицуулна” Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д “Энэ хуулийн 39.3-т заасан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн олборлолтын ажил эхлэхийн өмнө шилжүүлэх бөгөөд энэхүү шилжүүлэг хийгдсэн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ” гэж заасан бөгөөд хуулийн 39.3-т заасан хөрөнгө нь мөн хуулийн 39.1.9-д заасан хөрөнгө байхаар тусгасан байна.	БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.8-д “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална” гэж заасан нь ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэхээр байна. Энэ нь мөн БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь заалттай нийцэхгүй байна. (Уг заалтыг дор харуулсан)
	Төсөл хэрэгжүүлэгч: Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д “Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль	Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8 дахь заалттай нийцээгүй. Уг заалтад хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль		

	орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана”	хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэхээр заасан. Мөн БОМТБХБТЖ ¹ -ын 2.3-т дээрх байдлаар тусгасан.
	Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10-т “Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ”	Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.9, 39.3, 39.5 дахь заалтуудтай нийцээгүй. Мөн БОМТБХБТЖ-ын 2.3-т Байгалт орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын зардлын 50 хувийн барьцааг байршуулахаар заасан нь уг хуулийн заалттай зөрчилдөж байна.
Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8-д “Энэ хуулийн 38.1.8, 39.1.9-д заасан тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална ” гэж заасан.		
Харин БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.15-д “Энэ хуулийн 9.9, 9.10-т заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална ” гэж заасан нь дээрх заалттай нийцэхгүй байна.		
Мөн дээрх заалтуудад хамаарах этгээдийг Ашигт малтмалын тухай хуульд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч”, БОНБҮТХ-д “Төсөл хэрэгжүүлэгч”, Газрын тосны тухай хуульд “Гэрээлэгч” гэсэн нэршлээр тодорхойлсон нь уялдаагүй байна.		
Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч: Хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7-д “байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх”	БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх заалттай нийцээгүй. Уг заалтад төсөл хэрэгжүүлэгч нь сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулахаар заасан.
	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч: Хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Ашигт малтмалын тухай хуулийн 39.1-д заасан үүрэг хүлээнэ”	БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь заалттай нийцэхгүй байна.
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд	Журмын 2.3.1-д “Бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, ашиглалтын хайгуул, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагаар батлуулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажилд шаардагдах мөнгөн хөрөнгийг Байгаль	БОМТБХБТЖ-ын 2.3 дахь заалттай нийцээгүй.

¹ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан журам

хяналт тавих журам²	орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10-д заасан хувь хэмжээгээр”	
	Журмын 2.3.2-т “Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж буй сум, дүүргийн Засаг даргаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8-д заасан хувь хэмжээгээр”	
	Журмын 2.3.3-т “газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгч байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.10-д заасан хувь хэмжээгээр”	БОМТБХБТЖ-ын 2.3 дахь заалттай нийцээгүй.
	Журмын 2.3.4-д “Энэхүү журмын 2.3.1, 2.3.3-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.9-д заасан хувь хэмжээгээр”	БОМТБХБТЖ-ын 2.3 дахь заалттай нийцээгүй.

1.2. Дээрх байдлаас харахад нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах хуулийн зохицуулалтууд ялгаатай байна.

1.3. Харин тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулах баталгааны мөнгөн хөрөнгийг БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувиар тооцон төвлөрүүлж байна.

1.4. Зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данснаас гадна дараах дансанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиг үүргийн баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулахаар хуульчилсан байна.

Хууль тогтоомж	Зүйл, заалт	Тодруулга
Цөмийн энергийн тухай хууль	Хуулийн 28 дугаар зүйлийн 28.9-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна”	БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10 болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 2.3.3-т эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нь БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.10-д заасан хувь хэмжээгээр нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулахаар заасан байна.
Газрын тосны тухай хууль	Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д “байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай	

² Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/38 дугаар тушаалаар баталсан журам

тэнцэх мөнгөн хөрөнгийг жил бүр төлөвлөгөө батлагдсанаас хойш 60 хоногийн дотор Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулах”

1.5. Дээрх хууль, журмын зохицуулалтаас харахад эдгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх чиг үүргийн хүрээнд баталгааны мөнгөн хөрөнгийг **“хоёр удаа”** холбогдох дансанд тогтоосон хувь хэмжээгээр байршуулахаар байна.

1.6. Уг асуудлын талаар зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч холбогдох байгууллагад санал хүсэлт гаргасан байна. Тухайлбал:

Дорноговь аймгийн Хөвсгөл, Хатанбулаг, Мандах сумын нутагт Газрын тос хайх №85 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Смарт Ойл Монголиа” ХХК:

- Тус компани нь 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 24/13 дугаар “Дэмжлэг хүсэх тухай” албан бичгээр АМГТГ-т хүсэлт гарган “Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг дахин байршуулах нь компанийн санхүүгийн хувьд хүндрэлтэй байгаа тул БОУАӨЯ-нд хандаж эрх зүйн дэмжлэг үзүүлэх”-ийг илэрхийлсэн байна.

АМГТГ уг хүсэлтийн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 1/1132 дугаар “Баталгаа хөрөнгийн давхардлын тухай” албан бичгийг УУХҮЯ-нд (хуучин нэрээр) хүргүүлсэн байна.

Тус компанийн баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан байдлыг тулгаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Газрын тосны хуулийн 11.2.9-д заасны дагуу эскроу дансанд 2017 оноос 2024 онд жил бүр байршуулах үүрэгтэй боловч нэг удаа 2021 онд 64.968.0 мянган ам.доллар буюу Монгол банкны 2021.08.21 өдрийн ханшаар 185.1 сая төгрөгийг холбогдох банкны эскроу дансанд байршуулсан байна.
- Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2022 онд 25.5 сая төгрөг байршуулсан бөгөөд 2023, 2024 онд тус дансанд байршуулах нийт 48.8 сая төгрөгийг байршуулаагүй байна. Тус компани 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 24/11 дүгээр албан бичгээр 2022 онд байршуулсан 25.5 сая төгрөгийг дүйцүүлэн тооцох хүсэлтийг БОУАӨЯ-нд гарган БОМТ-г батлуулсан байна.

1.7. Дээрх байдлаас харахад холбогдох төрийн байгууллагууд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийн дагуу хууль, журамд нийцээгүй шийдвэрийг гаргаж байна.

Иймд нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулахтай холбоотой хууль, журмын ялгаатай зохицуулалтыг цэгцэлж, ойлгомжтой болгох шаардлагатай байна.

Бичил уурхай эрхлэгч этгээд


1.8. Бичил уурхай эрхлэгч этгээдийн хувьд тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулахаар Ашигт малтмалын тухай хуульд³ заасан бөгөөд ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар зохицуулж байна. Уг журамд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршуулах асуудлыг дараах байдлаар тусгасан байна.

³ Хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэж заасан.

Журмын 3.2.12 Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахын өмнө Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах барьцаа хөрөнгийг тухайн сумын **нөхөн сэргээлтийн дундын дансанд** байршуулах

1.9. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах үйл явцыг хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна.

Дүрслэл 1: Баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах үйл явцын зураглал



1.10. Дүрслэлээс харахад баталгааны мөнгөн хөрөнгийг БОМТ батлагдахаас өмнө нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулахаар байна.

1.11. Үүнтэй холбогдуулан зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулсан хэдий ч БОМТ батлагдаагүй байна.

Хүснэгт 1: Баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан ч БОМТ батлагдаагүй тусгай зөвшөөрлийн тоо, мөнгөн дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	2023 он		2024 он		2025.I улирал	
	Тусгай зөвшөөрлийн тоо	Байршсан мөнгөн дүн	Тусгай зөвшөөрлийн тоо	Байршсан мөнгөн дүн	Тусгай зөвшөөрлийн тоо	Байршсан мөнгөн дүн
Нийт	96	187.5	103	466.2	68	458.2
БОУАӨЯ	20	131.9	20	393.4	31	416.6
Ашигт малтмалын ашиглалт	16	118.8	17	377.9	27	370.7
Баяжуулах үйлдвэр	3	7.9	2	8.3	3	31.7
Газрын тосны ашиглалт	-	-	-	-	-	-
Газрын тосны хайгуул	1	5.1	1	7.1	1	14.3
Сум/дүүрэг	76	55.6	83	72.8	37	41.6
Ашигт малтмалын хайгуул	72	54.1	82	72.3	37	41.6
Түгээмэл ашиглалт	-	-	-	-	-	-
Түгээмэл хайгуул	4	1.5	1	0.5	-	-

Эх сурвалж: Аудиторын тооцоолол


1.12. 2023-2024 оны байдлаар жилд дунджаар 99 тусгай зөвшөөрөл баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулсан ч БОМТ нь батлагдаагүй байна.

1.13. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулаад БОМТ батлагдаагүй тохиолдолд тус мөнгөн хөрөнгийг хэрхэх талаар хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

1.14. Энэ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид байршуулсан мөнгөн хөрөнгийг дараа жил шилжүүлэн тооцуулах, БОМТ-гүй үйл ажиллагаа явуулах зэрэг зөрчил гаргах нөхцөлийг бүрдүүлж байна.

1.15. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн БОМТ батлуулж буй байдлыг авч үзвэл:

Дүрслэл 2: БОМТ-г илгээсэн, хянасан, баталсан цаглавар



Эх сурвалж: БОУАӨЯ-ны мэдээллийн сан /eis.mn/ (2025 оны мэдээлэл 6-р сарын байдлаар туссан)

1.16. Дээрх үйл явцаас харахад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн холбогдох байгууллагад батлуулахаар хүргүүлсэн БОМТ-ний дийлэнх нь 2-р улирлаас хойш батлагдаж байна. Энэ нь БОМТБХБТЖ-ын 2.8-д “Уул уурхайн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа уурхай, дэд бүтцийн барилга байгууламж, баяжуулах, боловсруулах үйлдвэр, зам, талбайг хамруулан төлөвлөх бөгөөд ус хангамж, ариутгах татуурга, химийн хортой болон аюултай бодис ашиглах, хадгалах байгууламж, туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг нэгтгэн тусгаж, эрх бүхий байгууллагын баталсан уулын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан жил бүрийн **эхний улиралд багтаан** эцэслэн баталгаажуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

1.17. Нөгөө талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь боловсруулсан БОМТ-г БОМТБХБТЖ-ын 2.1⁴-д заасан хугацаанд боловсруулаагүйгээс хугацаандаа батлагдахгүй байх нөхцөлийг үүсгэсэн байна. 2023 онд тухайн жилийн БОМТ-г дараа жил нь илгээж батлуулсан 5 тохиолдол гарсан байна. Мөн БОМТ хугацаандаа батлагдахгүй байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид шаардлага хангасан БОМТ ирүүлээгүйгээс буцаагдаж байгаатай холбоотой байна.

1.18. БОМТ батлагдаагүй болон хэт оройтож батлагдаж байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигч БОМТ-гүй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг үүсгэхээр байна. Энэ нөхцөл байдлыг тодруулахад:

Хүснэгт 2: БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч

Үзүүлэлт	2023 он	2024 он
Нийт	46	40
БОУАӨЯ	20	13

⁴ Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн **жил бүрийн 12 дугаар сард багтаан** дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

Ашигт малтмалын ашиглалт	17	9
Баяжуулах үйлдвэр	2	3
Газрын тосны ашиглалт	-	-
Газрын тосны хайгуул	1	1
Сум/дүүрэг	26	27
Ашигт малтмалын хайгуул	17	18
Түгээмэл ашиглалт	1	1
Түгээмэл хайгуул	8	8

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.19. Дээрх үзүүлэлтээс харахад 2023 – 2024 онд нийт 86 тусгай зөвшөөрөл эзэмшигч БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг хавсралт №1-т харуулав.

1.20. Энэ нь БОМТБХБТЖ-ын 3.1-д “Тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага хянан баталснаар **төслийн тухайн жилийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх үүснэ**” гэж заасантай нийцэхгүй байна.

1.21. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийг БОМТ-гүй ажилласан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасны дагуу “**Таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох**” зохицуулалттай бөгөөд БОУАӨЯ-ны Салбарын хяналтын газраас хийгдсэн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд 2023 онд 7 аймгийн 32 аж ахуй нэгжид **59.0** сая төгрөг, 2024 онд 11 аймгийн 57 аж ахуй нэгжид **83.5** сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

1.22. БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид дээрх торгуулийн арга хэмжээнээс өөр арга хэмжээ авахгүй байна. Тодруулбал торгуулиа төлөөд үйл ажиллагаагаа явуулах боломжтой байна. БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

1.23. БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан нь нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд төвлөрөх баталгааны мөнгөн хөрөнгө төвлөрөхгүй, цаашлаад ашигласан талбайд нөхөн сэргээлт хийгдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

1.24. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн батлуулсан БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийн дүнг гүйцэтгэлтэй нь харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 3: БОМТ, биелэлтийн тайлангийн мөнгөн дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	2023 он		2024 он	
	БОМТ-ний төлөвлөсөн зардал	БОМТ-ний биелэлтийн тайлангийн зардал	БОМТ-ний төлөвлөсөн зардал	БОМТ-ний биелэлтийн тайлангийн зардал
Нийт	19,114.8	32,464.9	20,233.8	39,262.9
БОУАӨЯ	18,179.3	26,515.8	19,110.5	33,385.4
Ашигт малтмалын ашиглалт	13,532.5	18,966.9	14,907.9	21,765.1
Баяжуулах үйлдвэр	1,274.1	4,398.4	1,832.3	9,175.3
Газрын тосны ашиглалт	3,216.9	2,954.1	2,177.5	2,309.7
Газрын тосны хайгуул	155.8	196.3	192.7	135.2
Сум/дүүрэг	935.5	5,949.1	1,123.3	5,877.5
Ашигт малтмалын хайгуул	596.0	131.5	747.3	48.1
Түгээмэл ашиглалт	208.4	5,767.7	271.6	5,827.9
Түгээмэл хайгуул	131.1	50.0	104.5	1.5

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.25. Дээрх үзүүлэлтээс харахад БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс илүү байна.


1.26. Энэ нь БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг бодитой тооцдоггүйг харуулж байна. Уг нөхцөл байдал нь нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид буцаан олгодоггүйгээс тусгай зөвшөөрөл эзэмшигчид тус дансанд бага хөрөнгө төвлөрүүлэх сонирхолтой холбоотой байж болзошгүй байна. Нөгөө талаар БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцох жишиг тариф байхгүйгээс уг зардал бодитой бус төлөвлөгдөж байна.

1.27. БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөн хөрөнгийг бодитой төлөвлөөгүйгээс нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулах мөнгөн хөрөнгө дутуу төвлөрч, цаашлаад ашигласан талбай нөхөн сэргээгдэхгүй, орхигдох сөрөг үр дагаврыг үүсгэхээр байна.

Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны орлогыг жил бүр бүрэн төвлөрүүлээгүй байна


1.28. Уул уурхайн чиглэлийн хайгуулын болон ашиглалтын нийт 4259 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байгаа ба эдгээр тусгай зөвшөөрлийг 2581 ААН эзэмшиж байна. Эдгээр тусгай зөвшөөрлийн БОМТ батлуулсан байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна.

Дүрслэл 3: БОМТ батлуулсан байдал /тоо/



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.29. Дээрх үзүүлэлтээс харахад нийт 4259 тусгай зөвшөөрлөөс 900-1000 тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа идэвхтэй байна. Нөгөө талаар нийт тусгай зөвшөөрлийн ойролцоогоор 75 хувь нь ашиглалтгүй буюу үйл ажиллагаа явуулахгүй байна.



БОУАӨЯ-ны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2025 оны 1-р улирлын байдлаар нийт **47.7** тэрбум төгрөг төвлөрсөн.

1.30. БОМТ батлуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгө байршуулсан байдлыг авч үзвэл:

Хүснэгт 4: Баталгааны тусгай дансанд байршуулбал зохих болон байршуулсан мөнгөн хөрөнгийн дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	2023 он			2024 он			2025.I улирал		
	Тусгай зөвшөөрлийн	Байршуулбал зохих мөнгөн дүн	Байршсан мөнгөн дүн	Тусгай зөвшөөрлийн тоо	Байршуулбал зохих мөнгөн дүн	Байршсан мөнгөн дүн	Тусгай зөвшөөрлийн	Байршуулбал зохих мөнгөн дүн	Байршсан мөнгөн дүн

Нийт	800	9,354.2	8,482.9	883	9,709.2	9,772.2	334	5,668.6	5,329.2
БОУАӨЯ	354	8,923.5	8,165.7	360	9,197.8	9,368.4	136	5,445.3	5,182.5
Ашигт малтмалын ашиглалт	322	6,664.6	5,634.8	327	7,112.1	7,151.1	118	4,503.4	4,178.4
Баяжуулах үйлдвэр	24	577.7	619.3	25	907.8	940.3	15	647.0	682.4
Газрын тосны ашиглалт	4	1,608.4	1,863.1	4	1,088.7	1,211.4	2	276.7	303.5
Газрын тосны хайгуул	4	72.8	48.6	4	89.2	65.6	1	18.3	18.3
Сум/дүүрэг	446	430.7	317.2	523	511.3	403.8	198	223.3	146.7
Ашигт малтмалын хайгуул	390	261.5	197.7	464	324.1	267.0	164	147.1	84.8
Түгээмэл ашиглалт	23	104.2	60.8	28	135.8	91.1	17	46.8	36.1
Түгээмэл хайгуул	33	65.0	58.7	31	51.5	45.7	17	29.3	25.8

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.31. Дээрх үзүүлэлтээс харахад БОМТ батлуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулбал зохих баталгааны мөнгөн хөрөнгийг бүрэн төвлөрүүлдэггүй байна.

1.32. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулбал зохих мөнгөн хөрөнгийг бүрэн төвлөрүүлээгүй нь дараах асуудалтай холбоотой байна. Тухайлбал:

- Баталгааны мөнгөн хөрөнгө байршуулаагүй БОМТ батлуулсан,
- Өмнөх онд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийг дараа онд шилжүүлэн тооцуулсан,
- Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данснаас өөр дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлсэн
- Бусад нөхцөл байдал

1.33. Баталгааны мөнгөн хөрөнгө байршуулаагүй БОМТ батлуулсан тусгай зөвшөөрлийн мэдээллийг харуулбал:

Хүснэгт 5: Баталгааны мөнгөн хөрөнгө байршуулаагүй БОМТ батлуулсан тусгай зөвшөөрлийн тоо, мөнгөн дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	2023 он		2024 он		2025.I улирал	
	Тусгай зөвшөөрлийн тоо	Байршуулбал зохих мөнгөн дүн	Тусгай зөвшөөрлийн тоо	Байршуулбал зохих мөнгөн дүн	Тусгай зөвшөөрлийн тоо	Байршуулбал зохих мөнгөн дүн
Нийт	200	408.9	224	310.3	146	143.0
БОУАӨЯ	20	289.5	15	202.6	10	64.4
Ашигт малтмал ашиглалт	17	251.4	14	178.9	8	57.5
Баяжуулах үйлдвэр	1	11.2	-	-	2	6.9
Газрын тосны ашиглалт	-	-	-	-	-	-
Газрын тосны хайгуул	2	26.9	1	23.6	-	-
Сум/дүүрэг	180	119.4	209	107.8	136	78.6
Ашигт малтмал хайгуул	152	69.6	180	65.1	114	64.3
Түгээмэл ашиглалт	7	43.4	9	37.2	9	10.7
Түгээмэл хайгуул	21	6.4	20	5.5	13	3.6

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.34. Дээрх үзүүлэлтээс харахад 2023-2025 онд нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд төвлөрүүлэх нийт 862.2 сая төгрөгийг байршуулаагүй БОМТ-г баталсан байна.

1.35. Зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилд нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийг дараа жилд шилжүүлэн тооцуулсан байна. Тухайлбал:

	Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байршилтай ашигт малтмалын MV-006709 тусгай зөвшөөрлийн дугаартай Оюутолгой ХХК • 2023 оны баталгааны мөнгөн хөрөнгө 957.5 сая төгрөгөөс 61.3 сая төгрөгийг байршуулж, үлдэгдэл 896.1 сая төгрөгийг 2007 оноос хойш байршуулсан баталгааны хөрөнгийг шилжүүлж тооцуулах тухай 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн НСЕ/117 албан бичгээр хүсэлт гарган шийдвэрлүүлж БОМТ-г батлуулсан байна.
 “ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ	Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байршилтай ашигт малтмалын MV-00011 тусгай зөвшөөрлийн дугаартай Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ • 2021, 2022 оны баталгааны мөнгөн хөрөнгө 585.0 сая төгрөгийг байршуулахгүйгээр шилжүүлэн тооцуулах тухай 2020 оны ТБ-126-12/8679 тоот, 2021 оны ДЧ-126-12/6436 тоот албан бичгүүдээр хүсэлт гарган шийдвэрлүүлж БОМТ-г батлуулсан байна.

1.36. Зарим тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч БОМТ батлуулсан ч үйл ажиллагаа явуулаагүй үед БОМТБХБТЖ-ын 2.7-д “*Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй талаарх тодорхойлолтыг төсөл хэрэгжиж буй сум, дүүргийн Засаг дарга, хэд хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн хувьд аймаг, нийслэлийн байгаль орчны газар тодорхойлсон байна*” гэж заасны дагуу сум дүүргийн Засаг даргаас тодорхойлолт авч тухайн жилд нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийг дараа жилд шилжүүлэн тооцуулсан байна. 2023-2025 онд нийт **19** тусгай зөвшөөрөл эзэмшигч **221.6** сая төгрөгийг дараа онд шилжүүлэн тооцуулсан байна. Энэ үйл явцыг нарийвчлан зохицуулсан хууль тогтоомжийн зохицуулалт байхгүй байна.

1.37. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баталгааны мөнгөн хөрөнгийг дутуу, байршуулаагүй болон дараа жилд шилжүүлэн тооцуулж⁵ байгаа нь БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10 дахь заалттай нийцэхгүй байна. **Уг зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.**

1.38. Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д “Энэ хуулийн 39.5-д заасан хугацаанд мөн хуулийн 39.1.9-д заасан мөнгөн хөрөнгийг шилжүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн **олборлолтын ажлыг зогсоох** эрхтэй” гэж заасан ч сумын Засаг дарга нар уг заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.39. Мөн дутуу төвлөрүүлсэн баталгааны мөнгөн хөрөнгийг нөхөн төлүүлэх талаар холбогдох байгууллагууд арга хэмжээ огт аваагүй байна.

1.40. Ашигт малтмалын хайгуул, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайд нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулахад дараах асуудал тулгарч байна. Тухайлбал:

- Зарим суманд нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс байхгүйгээс тухайн сумын бусад дансанд төвлөрүүлсэн байна. Тодруулбал:
 - Сумын байгаль хамгаалах сангийн данс,
 - АМНАТ (түгээмэл тархац)-ийн данс,
 - Орон нутгийн ерөнхий орлогын данс,
 - ЗДТГ-ын нөөц сангийн данс,

⁵ БОМТ батлагдсан ч үйл ажиллагаа явуулаагүй (Сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолттой) тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад

- Хоршоог хөгжүүлэх сангийн данс,
- ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс,
- Хөрөнгө оруулалтын барьцааны данс,
- Татварын бус орлогын данс,
- Зарим тохиолдолд сумын албан тушаалтны хувийн дансанд шилжүүлсэн.

Баталгааны мөнгөн хөрөнгийг өөр дансанд төвлөрүүлж байгаа нь зориулалт бусаар зарцуулах нөхцөлийг үүсгэсэн байна.

Сумдын бусад дансанд төвлөрүүлсэн зөрчилд албан шаардлага өгч, албан тушаалтны хувийн дансанд шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

- Сумдад нээсэн данс нь өөр өөр нэршилтэй байгаа нь төөрөгдөлд оруулж, зориулалт бусаар зарцуулах нөхцөлийг үүсгэж байна.

1.41. Сумдын нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны мэдээллийг харуулбал:

Хүснэгт 6: Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны тоо

Аймаг, нийслэл	Сум, дүүргийн тоо	Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны мэдээлэл /тоо/		
		Сангийн яаманд бүртгэлтэй данс	Данстай	Дансгүй
Архангай	19			19
Баян-Өлгий	13			13
Баянхонгор	20			20
Булган	16			16
Говь-Алтай	18		18	
Говьсүмбэр	3		3	
Дархан-Уул	4	1	4	
Дорноговь	14	11	14	
Дорнод	14		12	2
Дундговь	16		14	2
Завхан	24			24
Нийслэл	9	1	1	8
Орхон	2			2
Өвөрхангай	19			19
Өмнөговь	15	1	1	14
Сүхбаатар	13			13
Сэлэнгэ	17		7	10
Төв	27	1	19	8
Увс	19			19
Ховд	17			17
Хөвсгөл	24		3	21
Хэнтий	18		17	1
Нийт	341	15	111	230

Эх сурвалж: СаЯ, аудиторын тооцоолол

1.42. Дээрх үзүүлэлтээс харахад нийт 17 аймгийн 230 сум, нийслэлийн 8 дүүрэг нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансгүй байна. Данстай сум, дүүргээс 4 аймгийн 14 сум, нийслэлийн 1 дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс Сангийн яаманд бүртгэлтэй байна.

1.43. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данстай сумдын тус дансны нэршлийг авч үзвэл:

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа,
- Нөхөн сэргээлтийн сан,
- Нөхөн сэргээлтийн барьцаа,

- Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа,
Байгаль хамгаалах сангийн барьцаа хөрөнгө,

1.44. Дээрх байдлаас харахад ашигт малтмалын хайгуул, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрлийн баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж байгаа данс нь хууль, журамд зааснаас өөр нэршилтэй байна. Иймд дансны нэршлийг хууль, журамд заасны дагуу нэгдсэн байдлаар шийдвэрлэх асуудлыг СаЯ-нд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Бичил уурхай эрхлэгч этгээд

1.45. Бичил уурхай эрхлэгч этгээдийн нөхөн сэргээлтийн дундын дансанд барьцаа хөрөнгө байршуулсан байдлыг авч үзвэл:

Хүснэгт 7: Бичил уурхай эрхлэгчдийн 2020-2025 онд барьцаа хөрөнгө байршуулсан мэдээлэл. /сая төгрөг/

№	Аймаг	Олборлолт явуулахаар төлөвлөсөн талбай		Олборлолт явуулж байгаа талбайн хэмжээ /га/	Дундын дансанд байршуулбал зохих мөнгөн дүн	Дундын дансанд байршуулсан мөнгөн дүн
		тоо	хэмжээ /га/			
1	Баянхонгор	8	21.9	0	-	-
2	Булган	2	5.17	5.17	-	25.0
3	Говь-Алтай	81	238.48	238.48	142.0	142.0
4	Дорноговь	14	29.51	29.51	47.23	42.05
5	Дундговь	3	14.19	0	-	-
6	Өвөрхангай	16	45.42	45.42	4.6	-
7	Сэлэнгэ	52	81.11	81.11	201.16	205.35
8	Төв	11	18.79	18.79	47.4	47.4
9	Увс	72	0.12	0.12	123.39	37.75
10	Ховд	1	2.51	0	-	-
11	Хэнтий	26	32.14	32.14	47.8	47.8
Нийт		286	489.34	450.74	636.58	564.35

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

1.46. Дээрх үзүүлэлтээс харахад бичил уурхай эрхлэгчид дундын дансанд байршуулбал зохих барьцааны мөнгөн хөрөнгийг бүрэн байршуулаагүй байна. **Уг зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.**

БҮЛЭГ 2. Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна

Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг буцаан олгох хууль тогтоомжийн зохицуулалт ялгаатай байна

2.1. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд төвлөрсөн баталгааны мөнгөн хөрөнгийг зарцуулах үйл явцыг хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Хууль тогтоомж	Зүйл, заалт	Бусад хууль тогтоомжид утга агуулгын хувьд ялгаатай туссан байдал
Ашигт малтмалын тухай хууль	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч: Хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна”	
	Хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 38.1.8-д заасан хөрөнгийг түүнд буцааж өгнө”	
	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч: Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т “Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг бүрэн биелүүлээгүй тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна”	
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль	Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 39.1.9-д заасан хөрөнгийг түүнд уурхайн хаалтын үе шатанд буцааж өгнө”	БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалттай зөрүүтэй тусгагдсан. Уг заалтад БОМТ болон хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн тодорхой хуваарийн дагуу уурхайн хаалтын үе шатанд буцаан олгохоор заасан. Мөн БОХНСБТДГХТЖ-ын 3.1-д дээрх байдлаар тусгасан.
	Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11-т “Төсөл хэрэгжүүлэгчийн нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлага болон уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, энэ хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн энэ хуулийн 9.10-т заасан	Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4-т байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон БОМТ-нд заасан үүргээ бүрэн биелүүлсэн бол уурхайн хаалтын үе шатанд буцааж өгөхөөр заасан.

**Түгээмэл
тархацтай
ашигт
малтмалын
тухай хууль**

хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу уурхайн хаалтын үе шатанд буцаан олгоно”

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч:

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.3-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй бол сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 27.1.7-д заасан хөрөнгөөр байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулна”

Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т “Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол энэ хуулийн 27.1.7-д заасан хөрөнгийг түүнд буцааж өгнө”

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч:

Хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Ашигт малтмалын тухай хуулийн 39.1-д заасан үүрэг хүлээнэ”

БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалттай зөрүүтэй тусгагдсан. Уг заалтад БОМТ болон хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн тодорхой хуваарийн дагуу уурхайн хаалтын үе шатанд буцаан олгохоор заасан.

**Байгаль
орчныг
хамгаалах,
нөхөн
сэргээлтийн
баталгааны
тусгай
дансны
гүйлгээнд
хяналт
тавих журам**

Журмын 3.1-д “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлсэн бүх төрлийн ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэр, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх төсөл хэрэгжүүлэгчид энэхүү журмын 5.5 дахь хэсэгт заасан баримт бичиг, хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явц болон уурхайн хаалтын үе шатанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл, үр дүн, дүгнэлт, актыг үндэслэн тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан олгоно”

Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх заалттай зөрүүтэй тусгагдсан. Уг заалтад байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үүргээ бүрэн биелүүлсэн бол хөрөнгийг түүнд уурхайн хаалтын үе шатанд буцааж олгохоор заасан.

Журмын 3.2-т “Газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслөөс бусад ашигт малтмалын хайгуулын төсөл хэрэгжүүлэгч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, тусгай зөвшөөрлийг буцаан өгсөн тохиолдолд “тусгай зөвшөөрөлтэй талбайд нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах акт”-аар ажлын хэсэгт хүлээлгэж өгсөн баримт, харьяалах байгаль орчин, газрын дүгнэлт зэрэг баримт бичгийг үндэслэн буцаан олгоно”

Журмын 3.3-т “Журмын 3.1-д зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгчид тусгай дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг тухайн жилийн байгаль орчны

Хуулиудад байгаль орчны аудитын тайлангийн зөвлөмжийн хэрэгжилт гэж тусгагдаагүй.

менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, байгаль орчны аудитын тайлангийн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайлан, ажлын хэсгийн дүгнэлт болон журмын 2 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үндэслэн буцаан олгоно”

Журмын 3.4-д “Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлээгүй буюу бүрэн хэрэгжүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 39.3 дахь хэсгийг үндэслэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохих шатны Засаг дарга, Байгаль орчны газартай хамтран нөхөн сэргээлтийн ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд нэмж шаардагдах хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгчээс үл маргах журмаар гаргуулна”

2.2. Дээрх байдлаас харахад нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийг буцаан олгох хууль, журмын зохицуулалтууд ялгаатай байна. Уг асуудлыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.3. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данснаас баталгааны мөнгөн хөрөнгийг буцаан олгосон байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

БОУАӨЯ-ны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс	Тус данснаас нөхөн сэргээх арга хэмжээнд 2020 онд нийт 84.8 сая төгрөг зарцуулсан.
---	---

2.4. БОУАӨЯ-ны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны 2020-2025 оны зарлагыг авч үзэхэд 2020-2023 онд нийт 10 удаагийн гүйлгээгээр 372.2 сая төгрөгийн зарлага гарсан байна. Зарлагын гүйлгээг харуулбал:

Хүснэгт 8: Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны зарлага /сая төгрөг/

Он	Зарлага	Зарлагын задаргаа			Үлдэгдэл
2020	85.8	(1)	1.0	Илүү төлөлт буцаалт	17,927.7
		(2)	59.4	Нөхөн сэргээх зардал	
		(3)	25.4	Нөхөн сэргээх зардал	
2021	156.4	(4)	104.5	Барьцаа хөрөнгө буцаалт	19,789.6
		(5)	40.7	Барьцаа хөрөнгө буцаалт	
		(6)	1.4	Илүү төлөлт буцаалт	
		(7)	9.9	Илүү төлөлт буцаалт	
2022	59.5	(8)	54.5	Андуурсан гүйлгээ буцаалт	51,291.9
		(9)	5.0	Андуурсан гүйлгээ буцаалт	
2023	70.4	(10)	70.4	Андуурсан гүйлгээ буцаалт	32,683.5
2024	-	-	-	-	43,712.0
2025.03.31	-	-	-	-	47,689.7
Нийт	372.2	-			

Эх сурвалж: БОУАӨЯ

2.5. Хүснэгтийн мэдээллээс харахад нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2020 онд нийт 84.8 сая төгрөг зарцуулсан байна.

2.6. Уг зардлыг Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт “Эм Жи Эйч” ХХК-ны MV-009258 тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон 10 га талбайд мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгэх зориулалтаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/583 дугаар тушаалаар гаргасан байна.

2.7. Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэгчээр “Грийн фит” ХХК шалгарсан бөгөөд тус талбайд техникийн нөхөн сэргээлт хийн аймагт хүлээлгэн өгсөн байна.

Зураг 2: Эвдэрч орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийхийн өмнөх болон дараах байдал



Эх сурвалж: БОУАӨЯ

2.8. Дээрх талбайд байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн сэргээлт хийх зардалд мэргэжлийн байгууллагын тооцооллоор 52.6 га талбайд 1,636.5 сая төгрөг шаардлагатай ба энэ нь нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данснаас зарцуулсан мөнгөн хөрөнгө болох 84.8⁶ сая төгрөгөөс 19.3 дахин их байна. Мөн хуульд заасан шаардлагатай нэмэлт хөрөнгийг үл маргах журмаар тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргуулж аваагүй байна.

Нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн “Грийн фит” ХХК нь тус суманд нөхөн сэргээлт нэрийн дор 2021 онд хууль бус аргаар ашигт малтмалын олборлолт явуулсан нөхцөл байдал илэрч, хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна.

2.9. БОУАӨЯ-ны нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данснаас 2025 оны 1-р улирлын байдлаар дээрхээс өөр зарлага гараагүй байна.

Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс	Тус данснаас нөхөн сэргээх арга хэмжээнд 2020-2025 онд нийт 197.9 сая төгрөг зарцуулсан.
---	---

2.10. Сумдын нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны 2020-2025 оны зарлагыг гүйлгээг авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 9: Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны зарлага /сая төгрөг/

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025.1
Нийт	39.9	37.3	71.4	74.7	78.3	10.7
Зориулалтын дагуу	27.3	26.2	41.1	31.7	66.8	4.8
Зориулалтын бус	12.6	11.1	30.3	43.0	11.4	5.9

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.11. Дээрх үзүүлэлтээс харахад сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны хөрөнгийг зориулалт бус зарцуулсан зөрчил их байна.

2.12. Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны зориулалт бус зарлагыг ангилан харуулбал:

⁶ Уг баталгааны мөнгөн хөрөнгийг анх хэдэн оноос хойш тухайн аж ахуйн нэгж байршуулсан талаарх мэдээ, мэдээлэл, нотлох баримтууд БОУАӨЯ-нд байхгүй байна.

Хүснэгт 10: Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны зориулалт бус зарцуулалт /сая төгрөг

Он	Мөнгөн дүн	Зориулалт бус зарцуулсан зардлын төрөл
Нийт	114.3	-
2020	12.6	Шатахуун, бичиг хэрэг, цэвэрлэгээ, ковид хамгаалалт
2021	11.1	Мод зүлэг, суулгац, шатахуун, урамшуулал, зургийн аппарат
2022	30.3	Чанга яригч, нохой устгал, суулгац, усны шинжилгээний төлбөр, шатахуун
2023	43.0	Шатахуун, цэвэрлэгээ, сургалт зохион байгуулах, дансны шилжүүлэг, тор, шон худалдан авах
2024	11.4	Тээврийн зардал, хогийн цэгийн тор татах, дансны шилжүүлэг
2025	5.9	Мод, суулгац, мод тайрах багаж худалдан авах, шуудуу засвар, тоног төхөөрөмж засвар

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.13. Дээрх үзүүлэлтээс харахад нийт 114.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь сум, дүүрэгт нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс нээгээгүй, баталгааны мөнгөн хөрөнгийг бусад дансанд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

2.14. Баталгааны мөнгөн хөрөнгийг бусад дансанд төвлөрүүлсэн, зориулалт бус зарцуулсан зөрчилд **албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.**

Газрын тосны үйл ажиллагаанд хамаарах байгаль орчныг нөхөн сэргээх, барилга байгууламжийг татан буулгах баталгааны эскроу дансны зарлага

Газрын тосны тухай хуульд эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг буцаан олгох үйл явцыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т "гэрээлэгч үүргээ бүрэн биелүүлсэн бол буцаан олгох"

- Хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д "... эскроу дансанд байршуулсан мөнгийг байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, шаардлагатай тохиолдолд хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгахад зарцуулж, үлдсэн мөнгийг гэрээлэгчид буцаан олгоно"

Газрын тосны ашиглалтын болон хайгуулын 17 тусгай зөвшөөрөл эзэмшиж буй гэрээлэгч нар эскроу дансанд 2020-2024 онуудад 1.4 сая ам доллар байршуулсан ба энэ хугацаанд ямар нэгэн зарлага гараагүй байна.

Цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх баталгааны Төрийн сан дахь данс (УУХҮЯ-ны тусгай зөвшөөрлийн барьцаа данс)

Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.10-д "Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно" гэж заасан байна.

Дээрх заалтын дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо ордын ашиглалтын MV-018915 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "Бадрах энерги" ХХК-ийн ураны ордын технологийн туршилт явуулахтай холбогдуулан Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоол гарч УУХҮЯ-ны (хуучин нэрээр) тусгай зөвшөөрлийн барьцаа дансанд 2019 онд баталгааны мөнгөн хөрөнгө 900.0 мянган ам.доллар байршуулсан байна.

Тус данснаас 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар зарлага гараагүй байна.

Сум, дүүргийн бичил уурхайн нөхөн сэргээлтийн дундын дансны зарлага

2.15. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын 6.1.12-т “бичил уурхай эрхлэгч этгээд олборлолт явуулсан талбайг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн тохиолдолд нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг буцаан олгох” гэж заасан байна.

2.16. Нөхөн сэргээлтийн дундын дансны 2020-2025 оны зарлагын гүйлгээг авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 11: Нөхөн сэргээлтийн дундын дансны 2020-2025 оны зарлага /сая төгрөг/

№	Аймаг	Талбайн тоо	Талбайн мэдээлэл /га/			Нөхөн сэргээлтийн зардлын эх үүсвэр	
			Олборлолт явуулж байгаа	Эвдрэлд орсон	Нөхөн сэргээсэн	Дундын данс	Бусад эх үүсвэр
1	Баян-Өлгий	3	0.0	-	-	-	Дундын дансны хөрөнгөөс бусад эх үүсвэрээр санхүүжүүлсэн санхүүжилтийн мэдээлэл нь тодорхойгүй байна.
2	Баянхонгор	8	21.9	-	-	-	
3	Булган	2	5.2	0.5	-	-	
4	Говь-Алтай	81	238.5	-	-	-	
5	Дархан-Уул	5	0.0	12.1	15.6	-	
6	Дорноговь	14	29.5	12.2	12.2	-	
7	Дундговь	3	14.2	-	-	-	
8	Өвөрхангай	16	45.4	-	34.59	-	
9	Сэлэнгэ	52	81.1	21.9	33.16	160.4	
10	Төв	11	18.8	7.4	7.2	-	
11	Увс	72	0.1	0.13	0.1	21.5	
12	Ховд	1	2.5	-	-	-	
13	Хэнтий	26	32.1	3.5	-	-	
Нийт		294	489.3	57.73	102.85	181.9	

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.17. Дээрх үзүүлэлтээс харахад Сэлэнгэ, Увс аймагт нийт 33.26 га талбайд нөхөн сэргээлт хийж 181.9 сая төгрөгийг буцаан олгосон байна.

Эвдрэлд орсон болон нөхөн сэргээсэн талбай нь бичил уурхай эрхлэгчтэй холбоотой эсэх талаарх мэдээлэл холбогдох байгууллагуудад байхгүйгээс тоо баримтууд эцсийн байдлаар гаргаж баталгаажуулах боломжгүй байсан болно. Дээрх хүснэгтэд тусгасан мэдээлэл нь аудитын явцад цуглуулсан мэдээллийн хүрээнд гаргасан болно.

2.18. БОХНСБТДГХТЖ-ын 4.4-т “Тусгай дансанд байршуулах баталгааны мөнгөн хөрөнгийн хэмжээг цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй байлгаж, уг хөрөнгө нь зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн байгаль орчны төрийн захиргааны байгууллага хяналт тавина” гэж заасан ч хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Баталгааны мөнгөн хөрөнгийн хэмжээ, түүний зарцуулалтын талаар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд ямар нэгэн мэдээлэл тавигдаагүй тул олон нийт хяналт тавих боломж бүрдээгүй байна.
- Сумдын нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данснаас зориулалт бусаар зардал гарч байгаа нь аймаг, нийслэлийн байгаль орчны төрийн захиргааны байгууллагын хяналт муу байгааг харуулж байна.

2.19. Мөн БОХНСБТДГХТЖ-ын 4.1-д “Сум, дүүргийн тусгай дансанд байршуулсан баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг тухайн сум, дүүргийн Засаг дарга жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, дараа оны 01 дүгээр сарын 05-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн

байгаль орчны төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ” гэж заасан ч БОУАӨЯ-нд уг мэдээлэл байхгүй байна.

Нөхөн сэргээлтийн үйл явц хангалтгүй, эвдэрсэн талбайг бусад эх үүсвэрээр санхүүжүүлж нөхөн сэргээж байна

2.20. БОМТ батлуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан харуулбал:

Хүснэгт 12: Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл⁷ /га/

Он	Үзүүлэлт	Нөхөн сэргээлтийн төрөл	БОУАӨЯ				Сум/дүүрэг		
			Ашигт малтмал ашиглалт	Баяжуулах үйлдвэр	Газрын тосны хайгуул	Газрын тосны ашиглалт	Ашигт малтмал хайгуул	Түгээмэл ашиглалт	Түгээмэл хайгуул
2023	Төлөвлөгөө	Техник	773.5	8.0	1.0	53.6	21.8	5.5	47.4
		Биологи	401.0	8.8	0.0	13.4	11.1	2.0	7.0
		Дүйцүүлэх	886.9	32.0	0.0	3.0	10.5	59.5	4.5
	Тайлан	Техник	701.2	20.9	0.0	0.6	45.6	2.8	12.2
		Биологи	407.8	13.4	0.0	7.4	0.1	0.1	0.0
		Дүйцүүлэх	390.5	49.3	0.0	10.6	3.0	5.4	2.4
2024	Төлөвлөгөө	Техник	693.0	25.4	0.0	6.0	64.4	5.5	7.7
		Биологи	407.1	12.7	0.0	58.5	47.8	0.0	2.4
		Дүйцүүлэх	419.4	16.0	0.0	21.6	11.2	36.4	1.5
	Тайлан	Техник	654.4	22.7	0.6	3.0	53.1	3.8	1.1
		Биологи	405.2	11.6	0.0	4.0	25.5	0.0	0.0
		Дүйцүүлэх	348.6	44.5	0.0	0.0	0.2	2.1	1.5

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.21. Дээрх үзүүлэлтээс харахад “Баяжуулах үйлдвэр”-ээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлөвлөсөн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй байна.

2.22. БОМТБХБТЖ-ын 4.16 болон тус журмын 4 дүгээр хавсралтын “БОМТ-ний бүрэлдэхүүн хэсгийн биелэлтийн нийт онооны хүснэгт”-д БОМТ-ний биелэлт 90 оноо хүрээгүй бол хангалтгүй гэж үзэхээр тусгасан байна.

2.23. Уг хүснэгтэд нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтэд 30 оноо өгөхөөр тусгасан байна. Тодруулбал нөхөн сэргээлт хийгээгүй бол БОМТ хангалттай гэж үнэлэгдэх боломжгүй байна.

2.24. Гэсэн хэдий ч дээрх журам болон холбогдох хуулиудад БОМТ-ний биелэлт “Хангалттай” гэж үнэлэгдсэн тохиолдолд БОМТ-ний биелэлтийн тайланг баталгаажуулах зохицуулалт байхгүй байна.

2.25. Иймд БОМТ-ний биелэлт хангалттай, хангалтгүйгээс үл хамааран БОМТ-ний биелэлтийн тайлан батлагдаж байна. Тодруулбал төлөвлөсөн нөхөн сэргээлт хийгээгүй байхад тайлан нь батлагдаж байна. Үүнийг харуулбал:

Хүснэгт 13: Төлөвлөсөн нөхөн сэргээлт хийгээгүй БОМТ-ний биелэлтийн тайлан батлагдсан тусгай зөвшөөрлийн тоо

Он	БОМТ батлагдсан	Нөхөн сэргээлтийн төрөл	Нөхөн сэргээлт төлөвлөсөн	Нөхөн сэргээлт хийгдээгүй	Тайлан баталсан
2023	800	Техник	212	93	36
2024	883	Техник	216	100	38

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

⁷ Нөхөн сэргээлтийн хэмжих нэгжийг “га”-аар илэрхийлсэн үзүүлэлтийг нэгтгэн тусгасан болно. Биологийн болон дүйцүүлэх нөхөн сэргээлтэд өөр хэмжих нэгжээр илэрхийлсэн ажлууд хийгдсэн. Тухайлбал ширхэг мод тарьсан гэх мэт.

2.26. Энэ үзүүлэлтээс харахад нөхөн сэргээлт хийгдээгүй БОМТ-ний биелэлтийн тайлангийн дунджаар **38** хувь нь батлагдсан байна.

2.27. Дээрх нөхцөл байдал нь Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7-д “Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй” гэсэн заалт хэрэгжихгүй байхад нөлөөлөхөөр байна.

2.28. Аудитын явцад энэ заалтын дагуу нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй байхад олборлолтын ажлыг эхлүүлэхгүй хориглосон тохиолдол гараагүй болно.

2.29. Нөгөө талаар зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчид БОМТ-нд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй батлуулж БОМТ-ний биелэлтийг тайлагнаж батлуулсан байна.

Хүснэгт 14: Нөхөн сэргээлт төлөвлөөгүй БОМТ батлуулж, биелэлтийн тайлан батлагдсан тусгай зөвшөөрлийн тоо

Он	БОМТ батлагдсан	Нөхөн сэргээлтийн төрөл	Нөхөн сэргээлт төлөвлөөгүй	Тайлан баталсан
2023	800	Техник	588	311
2024	883	Техник	667	346

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.30. Дээрх үзүүлэлтээс харахад батлагдсан БОМТ-ний дунджаар **75** хувь нь техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй байна.

2.31. БОМТ-нд нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4-т “байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэ хуулийн 39.1.3-т зааснаас гадна дараах зүйлийг тусгах”, 39.1.4.4-т “энэ хуулийн 38.1.2-т заасан **нөхөн сэргээх** арга хэмжээ”,
- БОМТБХБТЖ-ын 1.5-д “Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ,
 - **Нөхөн сэргээх арга хэмжээ** (техникийн болон биологийн нөхөн сэргээлт),
 - Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ,
 - Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ,
 - Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ,
 - Химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ,
 - Хог, хаягдлын менежментийн арга хэмжээ,
 - Орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ,
 - Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

2.32. Дээрх нөхцөл байдлаас харахад нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд тавих холбогдох байгууллагуудын хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

2.33. Эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийхдээ ямар зориулалтаар нөхөн сэргээхийг тодорхойлох талаар холбогдох хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- БОНБУТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.4.6-д байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд “газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалт зэрэг төсөлд хаалтын үйл ажиллагааны чиглэл, **нөхөн сэргээлтийн зорилт**, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүд, дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ”-г тусгасан,

- Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) 2015 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн А-138 дугаар тушаалаар “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын 2.1-д эвдэрсэн газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулах чиглэлийг тусгасан. Уг чиглэлд:
 - Ил уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрыг хөдөө аж ахуйн, ойн аж ахуйн, усны аж ахуйн, тусгай зориулалт (Амралт, сувилал, спорт, байгаль хамгаалал, Барилга байгууламж) зэрэг чиглэлээр,
 - Далд уурхайгаар ашиглах явцад эвдэрсэн газрыг Газрын доорх агуулах, эмчилгээний камер, Сургалтын полигон, эсхүл битүүмжилж хаах зэрэг чиглэлээр нөхөн сэргээхээр тусгасан байна.
- УУХҮС, БОАЖС (хуучин нэрээр) нарын хамтарсан 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187, А/458 дугаар тушаалаар баталсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын 4.1-д “Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн явцын болон хаалтын нөхөн сэргээлтийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.4-д заасан журам, аргачлал болон холбогдох бусад хууль, журам, стандартын дагуу төлөвлөж, хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг хангана” гэж заасан.

2.34. Гэсэн хэдий ч нөхөн сэргээлт хийсэн газруудад дээрх заалтуудын дагуу зориулалтыг тодорхойлоогүй байна.

Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв:

2.35. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 182 дугаар тогтоолоор "Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв" Улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, тус байгууллагын дүрмийг хавсралтаар нь баталсан байна.

2.36. БОСШТ-ийн дүрмийн 4.1 -т “...*Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх судалгаа, шинжилгээний ажлыг олон улсын жишигт хүргэж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг төлөвшүүлэх*” эрхэм зорилгын хүрээнд “Байгаль орчны бохирдол, доройтлоос урьдчилан сэргийлэх, бохирдлыг бууруулах, саармагжуулах, нөхөн сэргээх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж, байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан таниулах, байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх сургалт, сурталчилгааг оновчтой явуулж, байгаль орчны хариуцлагатай үйл ажиллагааг хөгжүүлэх” гэж үндсэн хэрэгжүүлэх чиг үүргийг нь заасан байна.

2.37. Тус төвд зөвхөн 2023 онд уул уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой судалгаа, шинжилгээний ажил хийсэн байна. Уг ажлын хүрээнд 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшиж буй ААН-ийг 5 бүсэд хуваан тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны цар хүрээ, нөхөн сэргээсэн болон эвдрээгүй талбайн ургамалжилт, нөхөн сэргээлтийн стандартыг хэрхэн мөрдөж байгаа байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулж, нөхөн сэргээж байгаа талбай, эвдрээгүй газрын ургамлын зүйлийн бүрдлийн цуглуулга хийн мэргэжлийн судлаач, эрдэмтэдтэй хамтран таньж тодорхойлох ажлыг гүйцэтгэн дүгнэлт гаргасан байна.

2.38. Судалгаанд хамрагдсан аймгуудыг харуулбал:

- **Төвийн бүс:** Сэлэнгэ аймгаас 6 ААН, Төв аймгаас 26 ААН, Дархан-Уул аймгаас 8 ААН
- **Говийн бүс:** Дундговь аймгаас 10 ААН, Өмнөговь аймгаас 8 ААН
- **Хангайн бүс:** Архангай аймгаас 1 ААН, Өвөрхангай аймгаас 6 ААН, Баянхонгор аймгаас 19 ААН, Булган аймгаас 6 ААН, Орхон аймгаас 5 ААН, Хөвсгөл аймгаас 1 ААН,
- **Баруун бүс:** Ховд аймгаас 2 ААН, Увс аймгаас 2 ААН
- **Зүүн бүс:** Дорнод аймгаас 12 ААН, Хэнтий аймгаас 7 ААН, Сүхбаатар аймгаас 9 ААН

2.39. Судалгааны ажлын дүгнэлтэд нийт хэдэн га талбайд нөхөн сэргээлт хийгдсэн, хүрээлэн буй орчинд ямар нөлөө үзүүлж байгаа талаарх мэдээлэл гараагүй байна.

Эвдэрсэн газар	Эзэн холбогдогчтой нийт 4,496.8 га, эзэн холбогдогчгүй, орхигдсон нийт 9,616 га газар эвдэрсэн байна.
-----------------------	---

2.40. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайн мэдээллийг холбогдох байгууллагуудаас 2020-2025 оны байдлаар гаргуулан авахад дараах байдалтай байна.

Хүснэгт 15: Эвдэрсэн газрын мэдээлэл /мянган га/

Мэдээлэл ирүүлсэн байгууллага	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
	Эвдэрсэн газрын хэмжээ					
ҮСХ	27.1	11.3	11.4	-	-	-
БОУАӨЯ	-	-	-	-	-	39.57
ГЗБГЗЗЕГ,	-	-	-	-	8.55	-

Эх сурвалж: ҮСХ, БОУАӨЯ, ГЗБГЗЗЕГ

2.41. Дээрх байдлаас харахад эвдэрсэн газрын мэдээлэл холбогдох байгууллагуудад харилцан адилгүй байна. Энэ нь байгууллагууд харилцан уялдаатай ажилладаггүйг харуулж байна. Аудитын хугацаанд аймгуудаас эвдэрсэн газрын мэдээллийг гаргуулан авч нэгтгэхэд дараах байдалтай байна.

2.42. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын мэдээллийг авч үзэхэд эзэн холбогдогчтой, эзэнгүй орхигдсон гэсэн төлөвтэй байна. Эдгээр газрын мэдээллийг 2025 оны байдлаар харуулбал: Эвдэрч нөхөн сэргээгдээгүй газрын зургийг Хавсралт №2-т харуулав.

Эзэн холбогдогчтой газар:

Хүснэгт 16: Эвдэрсэн газар, түүний нөхөн сэргээлт /сая төгрөг/

Д/д	Аймаг	Олгосон газрын хэмжээ /га/	Үүнээс эвдэрсэн газрын хэмжээ /га/	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ /га/	Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан мөнгөн дүн
1	Архангай	5,580.6	537.97	48	-
2	Баян-Өлгий	8,818.73	30.3	0.54	3.0
3	Баянхонгор	235.6	235.6	-	-
4	Булган	1,671.65	132.44	-	-
5	Говь-Алтай	1,126.67	1,126.67	-	-
6	Дархан	628.8	628.8	117.4	1,821.5
7	Дорноговь	57.8	57.8	-	-
8	Дундговь	733.68	733.68	25.79	168.9
9	Завхан	413.6	157.6	-	-
10	Өвөрхангай	3,485.14	510.2	287.4	1,560.3
11	Сүхбаатар	-	54.21	14.2	-
12	Увс	2,963.8	42.86	-	-
13	Ховд	1,182.27	4.11	-	-
14	Хөвсгөл	149.22	132.69	-	-
15	Хэнтий	21,994.5	111.91	10	4.0
Нийт		49,042.02	4,496.8	503.31	3,557.7

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.43. Дээрх үзүүлэлтээс харахад нийт эвдэрсэн газрын 11 хувийг нөхөн сэргээсэн байна. Нөхөн сэргээхэд зарцуулсан мөнгөн хөрөнгийг эх үүсвэрээр авч үзвэл:

Хүснэгт 17: Нөхөн сэргээлтийн зардлын эх үүсвэр /сая төгрөг/

Нөхөн сэргээлт хийсэн санхүүжилтийн эх үүсвэр	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ /га/	Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан мөнгөн дүн
ААН-ийн хөрөнгөөр /дүйцүүлэх/	287.4	1,560.3
Орон нутгийн төсөв	12.7	12.5
Бусад	88.2	168.9
Нийт	503.3	3,557.7

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.44. Санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллээс харахад эвдэрсэн газрыг ихэвчлэн бусад ААН-ээр дүйцүүлэх байдлаар нөхөн сэргээж байна.

Эзэнгүй орхигдсон газар:

Хүснэгт 18: Эвдэрч эзэнгүй орхигдсон газар, түүний нөхөн сэргээлт /сая төгрөг/

Аймаг, нийслэл	Нөхөн сэргээгдээгүй, эзэнгүй орхигдсон газрын хэмжээ /га/	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ /га/	Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан мөнгөн дүн
Баян-Өлгий	50.5	-	-
Баянхонгор	491.9	25.6	-
Булган	228.7	97.2	-
Говь-Алтай	252.5	-	-
Дархан	284.3	284.3	7,118.3
Дорноговь	42.7	-	-
Дорнод	187.1	-	-
Дундговь	242.3	-	-
Орхон	0.6	0.5	-
Өвөрхангай	528.1	141.6	290.5
Сүхбаатар	96.6	19.3	1.9
Сэлэнгэ	4,161.5	2,811.2	53,204.6
Төв	1,354.6	639.2	41.0
Налайх	338.0	149.7	1.6
Увс	130.0	-	-
Ховд	120.0	75.8	146.6
Хэнтий	906.6	-	-
Нийт	9,616.1	4,244.4	60,804.6

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.45. Дээрх үзүүлэлтээс харахад нийт эвдэрсэн газрын 44 хувийг нөхөн сэргээсэн байна. Нөхөн сэргээхэд зарцуулсан мөнгөн хөрөнгийг эх үүсвэрээр авч үзвэл:

Хүснэгт 19: Нөхөн сэргээлтийн зардлын эх үүсвэр /сая төгрөг/

Нөхөн сэргээлт хийсэн санхүүжилтийн эх үүсвэр	Нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ /га/	Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан мөнгөн дүн
ААН-ын хөрөнгөөр /дүйцүүлэх/	3,597.1	56,506.4
Бичил уурхайн нөхөрлөлүүд	43.5	90.5
Бусад	18.2	-
Орон нутгийн төсөв	228.4	204.1
Улсын төсөв	215.5	4,003.5
Нийт	4,244.4	60,804.6

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.46. Санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллээс харахад эвдэрсэн газрыг ихэвчлэн бусад ААН-ээр дүйцүүлэх байдлаар нөхөн сэргээж байна.

2.47. Мөн улс, орон нутгийн төсвөөс багагүй хөрөнгө зарцуулсан байна. Энэ нь улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бусад салбарт хэрэгжих арга хэмжээний боломжийг алдагдуулсан байна.

2.48. Эвдэрч, орхигдсон талбайг бусад эх үүсвэрээр санхүүжүүлэн нөхөн сэргээж байгаа нь баталгааны мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй, нэмж шаардагдах хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үл маргах журмаар гаргуулах зохицуулалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

2.49. Нөхөн сэргээлт хийгээгүйтэй холбоотой зөрчилд холбогдох байгууллагуудын авсан арга хэмжээнээс үзвэл:

БОУАӨЯ, Салбарын хяналтын газар:

2.50. Хариуцлагын дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд:

- Тус яамнаас 2024 онд Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанд 69 тусгай зөвшөөрөл бүхий 64 ААН 1104.5 га газарт нөхөн сэргээлт хийлгүй орхисон, 64 тусгай зөвшөөрөл бүхий 64 ААН 1080.21 га газарт нөхөн сэргээлт хангалтгүй хийгдэж буй газруудын мэдээллийг хүргүүлсэн байна. Цагдаагийн ерөнхий газраас хариу албан бичиг ирүүлээгүй байна.
- 2024 онд салбарын хяналтын газраас төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт, улсын ерөнхий байцаагчийн удирдамжийн дагуу уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН-дэд байгаль орчны хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийж 140 ААН-д **191.1** сая төгрөгийн торгох шийтгэл, **2,565.9** сая төгрөгийн байгаль орчинд учруулсан хохирол, нөхөн төлбөр оногдуулж, улсын байцаагчийн албан даалгавраар зөрчлийн үр дагаврыг арилгахыг даалгаж, **19** ААН-д эрх хязгаарлах арга хэмжээ авч, **4** ААН-д албадлагын арга хэмжээ авхуулахаар шүүхэд шилжүүлэн ажилласан байна.
- 2019-2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) А/425 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Архангай, Баянхонгор, Өмнөговь, Завхан, Увс аймгийн 32 ААН, байгууллагын **41** ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлуулах дүгнэлт, 2022 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын (хуучин нэрээр) А/152 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлт, АМГТГ-ын даргын 1/4449 тоот албан бичгийг тус тус үндэслэн **7** ААН-ийн **7** тусгай зөвшөөрлийг цуцлуулах хүсэлтийг УУХҮЯ болон АМГТГ-т албан бичгээр хүргүүлсэн байна.

Үүнээс 2025 оны 05 дугаар сарын байдлаар **41** ААН-ээс **23** ААН-ийн **26** тусгай зөвшөөрөл, **7** ААН-ийн **7** тусгай зөвшөөрөл хүчинтэй хэвээр байна.

ЦЕГ-ын дэргэдэх Экологийн цагдаа алба:

2.51. Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд хууль бусар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох төрлийн нийт 1104 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэг бүртгэлтийн 516 хэргийг хаах 20 хэргийг нэгтгэх мөрдөн байцаалтын 505 хэргийг шүүхэд шилжүүлэх, 12 хэргийг нэгтгэх, 2 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорын байгууллагад шилжүүлэн ажилласан байна. Эдгээр зөрчлийг он оноор харуулбал:

Хүснэгт 20: Хууль бус ашигт малтмал олборлосон зөрчлийн шийдвэрлэлт

№	Он	Нийт хэрэг	шийдвэрлэсэн хэрэг	Үүнээс					Ажиллагааны хэрэг
				Хэрэг бүртгэлтийн хэргийн шийдвэрлэлт		Мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт			
				Хаасан	Нэгтгэсэн	Шүүхэд шилжүүлсэн	Нэгтгэсэн	Хэрэгсэхгүй болгосон	
1	2020	362	360	201	10	143	6		2
2	2021	218	218	102	3	111	2		

3	2022	207	203	106	1	94	1	1	4
4	2023	140	134	45	3	85	1		6
5	2024	177	140	62	3	72	2	1	37
Нийт		1104	1055	516	20	505	12	2	49

Эх сурвалж: Экологийн цагдаагийн алба

2.52. Дээрх мэдээллээс харахад нийт хэргийн 95 хувийг шийдвэрлэн ажилласан байна.

2.53. Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйл “Ашигт малтмалын тухай хууль зөрчих” зөрчил нь Экологийн цагдаагийн албанд харьяалагддаггүй бөгөөд энэ төрлийн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг илрүүлэн шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 21: Зөрчлийн шийдвэрлэлт

Шийдвэрийн утга	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Харьяаллын дагуу шилжүүлсэн	37	13	45	189	213
Зөрчлийн шинжгүй татгалзсан	2	3	2	2	1
Нийт	39	16	47	191	214

Эх сурвалж: Экологийн цагдаагийн алба

2.54. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Шадар сайд, БОАЖС, УУХҮС, ХЗДХС нарын 2020 оны 167, А/698, А/336, А/242 дугаарт хамтарсан тушаалаар Нөхөн сэргээлт-2024 арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.

2.55. Нөхөн сэргээлт-2024 нэгдсэн арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын 2 дүүргийн 3 байршил, 20 аймгийн 70 сумын 192 байршилд улсын төсвийн 69 сая, аж ахуйн нэгжийн 4.1 тэрбум төгрөгийн хөрөнгөөр нийт 9773 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 2549 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлэн, мөн нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгээгүй гэх үндэслэлээр 79 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж 5 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шүүхэд шилжүүлэн шийдвэрлүүлсэн байна.

2.56. Аудитын хугацаанд аймгуудаас илэрсэн зөрчлийн шийдвэрлэлтийн мэдээг авахад дараах байдалтай байна.

Хүснэгт 22: Зөрчлийг шийдвэрлэсэн байдал

№	Эрх бүхий байгууллагуудаас гаргасан шийдвэр	Арга хэмжээний тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Нөхөн сэргээгдээгүй, эзэнгүй орхигдсон талбайн хэмжээ /га/
1	Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээсэн	3	3	15.5
2	Тусгай зөвшөөрлийг цуцлуулсан	2	2	25.4
3	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	4	4	24.0
4	Шүүхийн маргаантай байгаа ба эцсийн шийдвэр гараагүй	4	4	225.1
Нийт		13	13	290.1

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.57. БОМТ-ний биелэлтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх асуудлыг хууль тогтоомжид дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7-д “Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тус тус хүргүүлэх”,
- БОМТБХБТЖ-ын 4.1-д “Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан

биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ”,

- БОНБҮТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.8-д “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална”

2.58. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн БОМТ-ний биелэлтийн тайлан гаргаж баталгаажуулсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 23: БОМТ-ний биелэлтийн тайлан /тоо/

Үзүүлэлт	2023 он			2024 он		
	Батлагдсан БОМТ	Батлуулахаар илгэсэн биелэлтийн тайлан	Үүнээс:	Батлагдсан БОМТ	Батлуулахаар илгэсэн биелэлтийн тайлан	Үүнээс:
			Батлагдсан биелэлтийн тайлан			Батлагдсан биелэлтийн тайлан
Нийт	800	550	502	883	603	525
БОУАӨЯ	354	305	251	360	304	220
Ашигт малтмал ашиглалт	322	275	224	327	274	196
Баяжуулах үйлдвэр	24	23	20	25	23	19
Газрын тосны ашиглалт	4	2	2	4	2	1
Газрын тосны хайгуул	4	5	5	4	5	4
Сум/дүүрэг	446	245	251	523	299	305
Ашигт малтмал хайгуул	390	206	210	464	253	263
Түгээмэл ашиглалт	23	18	17	28	21	17
Түгээмэл хайгуул	33	21	24	31	25	25

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.59. Дээрх үзүүлэлтээс харахад БОМТ батлуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунджаар 31 хувь нь БОМТ-ний биелэлтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

2.60. БОМТ-ний биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох байгууллагад тайлагнаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-н 2 дах хэсэгт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан ч дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд энэ заалтын дагуу торгууль ногдуулаагүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх хууль тогтоомжийн зохицуулалт ялгаатай, тодорхой биш, мөн баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулах этгээдийг өөр өөр нэршлээр тодорхойлсон нь баталгааны мөнгөн хөрөнгийг ялгаатай байдлаар төвлөрүүлэх нөхцөлийг үүсгэсэн байна.
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг үнэн зөв, бодитой тооцоолоогүй, хууль тогтоомжид заасан хугацаанд батлагдахгүй байгаагаас баталгааны мөнгөн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй, цаашлаад эвдэрсэн газрын хохирлыг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүсгэж байна.
3. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг зарцуулах хууль тогтоомжийн зохицуулалт ялгаатай, тус мөнгөн хөрөнгийг уурхайн хаалтын үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигчид буцаан олгохоор байгаа нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг бодитой бус төлөвлөх нөхцөлийг үүсгэж байна.
4. Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулсан, нөхөн сэргээлтийг хийгээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаагүй тусгай зөвшөөрөл эзэмшигчид хуульд заасан арга хэмжээг холбогдох албан тушаалтнууд аваагүйгээс эвдэрч орхигдсон газрын хэмжээ нэмэгдэх эрсдэлтэй байна.
5. Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс хууль тогтоомжийн дагуу нээгдээгүй, баталгааны мөнгөн хөрөнгийг бусад дансанд төвлөрүүлсэн нь баталгааны мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, эвдэрсэн газар нөхөн сэргээгдэхгүй орхигдох эрсдэлийг дагуулж байна.
6. Нөхөн сэргээлтийг бүрэн болон огт хийгээгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой нэмэлт зардлыг гаргуулаагүй, эвдэрч орхигдсон газрыг ихэвчлэн улс, орон нутгийн төсөв болон бусад компаниар дүйцүүлэх байдлаар нөхөн сэргээж байна. Нөхөн сэргээсэн газрыг ямар зориулалтаар ашиглахыг огт тодорхойлоогүй байна.
7. Уул уурхайн нөхөн сэргээлт, эвдэрч орхигдсон газрын талаарх холбогдох байгууллагуудын мэдээлэл уялдаагүй, зөрүүтэй, улсын хэмжээний нэгдсэн бодитой тоо мэдээлэл байхгүйгээс нөхөн сэргээсэн газарт тусгай зөвшөөрөл олгосон тохиолдол гарсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад:

- Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, буцаан олгохтой холбоотой хууль тогтоомжийн ялгаатай асуудалд дүн шинжилгээ хийж эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх,
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хууль тогтоомжид заасны дагуу үнэн зөв, бодитой боловсруулсан эсэхийг бодит гүйцэтгэлтэй харьцуулан хяналт тавьж, хууль тогтоомжид нийцүүлэн, тогтоосон хугацаанд батлах,
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлах, биелэлтийн тайланг тайлагнахтай холбоотой хууль тогтоомжийн зөрчил, холбогдох тусгай зөвшөөрөл эзэмшигчид хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох асуудалд хяналт тавьж зөрчлийг арилгах арга хэмжээг хагас жил тутам зохион байгуулах,
- Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны баталгааны мөнгөн хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын жилийн тайланг нэгтгэн дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авч ажиллах.
- Нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд баталгааны мөнгөн хөрөнгийг байршуулсан ч байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдаагүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлагдсан ч үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд баталгаа мөнгөн хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх талаарх эрх зүйн орчныг тодорхой болгож эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх.
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй үйл ажиллагаа явуулсан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт хангалтгүй үнэлэгдсэн зэрэг асуудалд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг зогсоох эрх зүйн зохицуулалтыг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх.
- Нөхөн сэргээгдээгүй эвдэрч орхигдсон газрын эзэн холбогдогчийг тогтоон нөхөн сэргээлгэх, шаардлагатай хөрөнгийг гаргуулах ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулж, нөхөн сэргээх газрыг ямар зориулалтаар ашиглахыг тодорхойлох асуудлыг нэгдсэн байдлаар зохион байгуулах.

Сангийн сайдад:

- Сум, дүүргийн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны нэршил өөр өөр байгаад судалгаа хийж, хууль тогтоомжид заасны дагуу, нэг нэршилтэй болгох,
- Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа сум, дүүрэгт нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс байхгүй тохиолдолд тус дансыг нээх асуудлыг нэгдсэн байдлаар зохион байгуулах.

Үндэсний статистикийн хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга нарт:

- Уул уурхайн нөхөн сэргээлт, эвдэрч орхигдсон газрын талаарх мэдээллийн уялдааг хангаж, нэгдсэн мэдээллийн сан бий болгон хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангах.

Хууль зүй, дотоод хэргийн сайдад:

- Нөхөн сэргээгдээгүй эвдэрч орхигдсон газрын эзэн холбогдогчийг тогтоон нөхөн сэргээлгэх ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 19 66, Цахим шуудан: contact@mecc.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2025.07.04 № 02/3472
танай _____-ны № 01/2021 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай 2025 оны 01/2021 дугаар албан бичгээр
ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны
"Аудитын сэдэв батлах тухай" 05 дугаар тогтоолыг
үндэслэн гүйцэтгэсэн "Уул уурхайн нөхөн сэргээлтийн
сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө" сэдэвт
нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж,
холбогдох тайлбар, санал, нотлох баримтыг хүргүүлж
байна.

Хавсралт ... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.УРТНАСАН



1525002298

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

- Баталгааны мөнгөн хөрөнгийг дутуу болон огт төвлөрүүлээгүй зөрчилтэй холбогдуулан зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчийн холбогдох нотлох баримтыг ирүүлснийг үндэслэн зөрчлөөс хасаж аудитын тайланд өөрчлөлт оруулсан болно.

БОМТ-гүй үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрлийн жагсаалт, 2023-2024 он

д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг, нийслэл	Эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Төрөл	Яам, сум, дүүрэг
2023 он						
1	628	Өмнөговь	Метан газ ресурс	6435254	Газрын тосны хайгуул	БОУАӨЯ
2	MV-000286	Дорнод	Дун-Уянга	3557588	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
3	MV-000349	Говьсүмбэр, Дундговь	Эрэл	2027194	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
4	MV-000400	Дорнод	Дамбат	2618532	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
5	MV-000859	Дундговь	Хандээж	2012251	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
6	MV-004591	Улаанбаатар	Шинэ тоосго ХХК	2579057	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
7	MV-006853	Баянхонгор	Ододгоулд	5180252	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
8	MV-006911	Ховд	Монголиан нэшнл рийр ийрт корп	5401801	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
9	MV-007134	Улаанбаатар	Цээцээ-Импекс ХХК	2804816	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
10	MV-009598	Ховд	Одцэ	2086999	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
11	MV-012335	Ховд	Монголиан нэшнл рийр ийрт корп	5401801	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
12	MV-013331	Дархан-Уул	Барилга-Орд	2640635	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
13	MV-015573	Улаанбаатар	Монголын алт МАК ХХК	2095025	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
14	MV-017106	Ховд	Монгол тунжөн майнинг инвестмент групп	6454763	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
15	MV-017291	Дорноговь	Талст дөл	5105439	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
16	MV-020486	Баян-Өлгий	Түвшингарав	5116635	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
17	MV-022103	Өвөрхангай	Өгөөмөр-Өргөө	2681404	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
18	MV-022152	Сэлэнгэ	Хандгайтгол	2059681	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
19	Баяжуулах	Өмнөговь	Говь ресурс девелопмент	5333903	Баяжуулах үйлдвэр	БОУАӨЯ
20	Баяжуулах	Хэнтий	Вин капитал	5658918	Баяжуулах үйлдвэр	БОУАӨЯ
21	MV-11000227	Улаанбаатар	Жи Эс Эн Ди ХХК	5511577	Түгээмэл ашиглалт	Сум/дүүрэг
22	XV-019114	Төв	Монгол металл консалтинг	5946239	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
23	XV-019466	Дорноговь	Улиастайчулуу	5233739	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
24	XV-019614	Дорноговь	Юү Ти Эм Эн	6049931	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
25	XV-019825	Сэлэнгэ, Төв	Арвинбаялгийн эрэлд	5368456	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг

Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө

26	XV-019974	Дорноговь	Шинэбаялаг	5155312	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
27	XV-020077	Дорноговь	Креско майнинг	5984041	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
28	XV-020159	Дорнод	Их ноёд пропертийз	5975298	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
29	XV-020361	Дорноговь	Гранд Самсара Консалтинг	6874908	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
30	XV-020375	Дундговь	Эхлэл ургац энерги	5353564	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
31	XV-020937	Өмнөговь	Азийн эртний зулай	5070678	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
32	XV-020259	Дорноговь	Дунгоулд	5455219	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
33	XV-022042	Дорноговь	Буман сор од	6790216	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
34	XV-022177	Дорноговь	Ачит минерал	6182526	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
35	XV-022209	Баян-Өлгий	Хэндфүл сийд	6948413	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
36	XV-022464	Төв	Хульж гоо	6507581	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
37	XV-022498	Сүхбаатар	Чэн юань Гү Жи	8365946	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
38	XV-021481	Дорноговь	Нобель трейд	5948061	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
39	XV-46000086	Өмнөговь	Гонуу	6354394	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
40	XV-46000090	Өмнөговь	Газрын зурвас	5311349	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
41	XV-46000091	Өмнөговь	Голден хаммер	5045894	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
42	XV-46000122	Өмнөговь	Ихсарана	5399017	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
43	XV-46000123	Өмнөговь	Оймон	5017629	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
44	XV-48000012	Дундговь	Авто мото хурд майнинг	293890	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
45	XV-61000006	Орхон	Ууган гарьд групп	4410874	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
46	XV-61000011	Орхон	Сансарын эрин	4377354	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
2024 он						
47	628	Цогтцэций	Метан газ ресурс	6435254	Газрын тосны хайгуул	БОУАӨЯ
48	MV-001903	Налайх	Ай Эф соонс ХХК	2741288	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
49	MV-004658	Хонгор	Идэрхайрхан	2169967	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
50	MV-004780	Цэнхэр	Армико майнинг корпорац	3020886	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
51	MV-009918	Уулбаян	Сунхунголд	5524997	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
52	MV-016833	Хонгор	Инноваложиистик	5718902	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
53	MV-017106	Мянгад	Монгол тунжөн майнинг инвестмент групп	6454763	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ

Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө

54	MV-020930	Алтай	Талстмолор	5774047	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
55	MV-021465	Өлзийт	Би Эс Ай	5035503	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
56	MV-021981	Алтанцөгц	Монгол бао жиэ зи юань	6952305	Ашигт малтмал ашиглалт	БОУАӨЯ
57	Баяжуулах	Цогтцэций	Говь ресурс девелопмент	5333903	Баяжуулах үйлдвэр	БОУАӨЯ
58	Баяжуулах	Сүхбаатар	Резевоир Монголиа	5028353	Баяжуулах үйлдвэр	БОУАӨЯ
59	Баяжуулах	Дархан	Арвижих хүдэр	6073549	Баяжуулах үйлдвэр	БОУАӨЯ
60	MV-11000227	Улаанбаатар	Жи Эс Эн Ди ХХК	5511577	Түгээмэл ашиглалт	Сум/дүүрэг
61	XV-017720	Говь-Алтай	Эдрэн гоулд ресурс	6610897	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
62	XV-019081	Дорнод	БСБА	5030986	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
63	XV-019114	Төв	Монгол металл консалтинг	5946239	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
64	XV-019341	Дундговь	Иннова минерал	6058132	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
65	XV-019466	Дорноговь	Улиастайчулуу	5233739	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
66	XV-019604	Дорноговь	Баянсүмбэр Богд	5065844	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
67	XV-019614	Дорноговь	Юү Ти Эм Эн	6049931	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
68	XV-020077	Дорноговь	Креско майнинг	5984041	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
69	XV-020599	Дорнод	Тэнгис констракшн	2729016	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
70	XV-020740	Увс	Хосбаян богд	5329191	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
71	XV-020745	Говь-Алтай	МОЭНКО	5141583	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
72	XV-021196	Говь-Алтай	Эдрэн гоулд ресурс	6610897	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
73	XV-021994	Төв	Нүүрс хими технологи	5966302	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
74	XV-021999	Өмнөговь	Аурум Металс	5005094	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
75	XV-022033	Дорноговь	Алтайн хар азарга групп	5118344	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
76	XV-022168	Орхон	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	2074192	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
77	XV-022216	Дорноговь	Эйтэрнэти скай трейд	6658849	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
78	XV-022650	Дорнод	Алтан наран ресурс	6198414	Ашигт малтмал хайгуул	Сум/дүүрэг
79	XV-46000086	Өмнөговь	Гонуу	6354394	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
80	XV-46000090	Өмнөговь	Газрын зурвас	5311349	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
81	XV-46000093	Өмнөговь	Голден хаммер	5045894	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
82	XV-46000122	Өмнөговь	Ихсарана	5399017	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
83	XV-46000123	Өмнөговь	Оймон	5017629	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг

Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө

84	XV-46000158	Өмнөговь	Говь номгон тэнгэр	3644693	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
85	XV-48000012	Дундговь	Авто мото хурд майнинг	293890	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг
86	XV-61000016	Орхон	Дайрга уул	4396847	Түгээмэл хайгуул	Сум/дүүрэг

оОо

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч нөхөн сэргээгдээгүй газар



Газрын байршил: Дорноговь аймгийн Айраг сумын Бор толгой гэх газар
Тусгай зөвшөөрөл эзэмшигч: Монголросцветмет ТӨҮГ, /22.4 га/




Газрын байршил: Дорноговь аймгийн Айраг сумын Хайрт гэх газар
Тусгай зөвшөөрөл эзэмшигч: Монголросцветмет ТӨҮГ, /43.9 га/
Орон нутаг 2023 онд тусгай хэрэгцээнд авсан.



Газрын байршил: Дорноговь аймгийн Даланжаргалан сум Баруун далан гэх газар
Тусгай зөвшөөрөл эзэмшигч: Чингисийн хар алт ХХК /37.78 га/
2018 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй.



Газрын байршил: Дорноговь аймгийн Даланжаргалан сум Боон толгой гэх газар
Тусгай зөвшөөрөл эзэмшигч: Казман контакт ХХК /34.86 га/
Экологийн цагдаагийн албанд шалгагдаж байна.



Газрын байршил: Дорноговь аймгийн Иххэт сумын Хашаат гэх газар
Тусгай зөвшөөрөл эзэмшигч: “Чандмань-илч” ОНӨ ХХК /10 га/



Газрын байршил: Дорноговь аймгийн Иххэт сумын Цагаан элгэн гэх газар
Тусгай зөвшөөрөл эзэмшигч: Болор оюун жонш ХХК /8 га/



Газрын байршил: Дорноговь аймгийн Даланжаргалан сум Улаан нуур гэх 3.5 га газарт нөхөн сэргээлт хийсэн талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон.



Газрын байршил: Дундговь аймгийн Өлзийт сумын Хүрэн дэл, Тооройн ханан, Арслан хад, Чулуун хороот, Гурван ухаа.

Тус газруудад 2001-2002 онд “Монгол газар” ХХК нь олборлолтын үйл ажиллагаа явуулж 2010 онд тусгай зөвшөөрөл цуцлагдаж, аймгийн Байгаль орчны газраас 2023 онд мэдээллийг БОАЖЯ-д хүргүүлсний дагуу Экологийн цагдаагийн албанаас дээрх асуудлыг шалгаж, хэргийн талаарх гомдол, мэдээллийг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт явуулсан байна.

Холбогдох материалыг Дундговь аймгийн прокурорын газрын хяналтын прокуророос хянаж, нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүй үйлдэл нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад зааснаар гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш таван жил өнгөрч, гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусан үндэслэлээр 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэжээ.



Газрын байршил: Архангай аймгийн Цэнхэр сум

Тусгай зөвшөөрөл эзэмшигч: Монгол газар ХХК, /182.4 га/

Энэ байршилд тус компани МВ-002426 дугаартай 119.1 га, МВ-002427 дугаартай 63.3 га газар эзэмшиж байсан ба тусгай зөвшөөрөл нь 2020 онд цуцлагдсан байна. Тус компани тусгай зөвшөөрөл сэргээхээр шүүхэд хандсан ба эцэслэн шийдэгдээгүй байна.